



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 6/26

Дадал сум

Ж.Хоридойг Засаг даргын орлогчоор
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.22 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын орлогчоор томилогдохоор нэр дэвшсэн (Жамсранжавын Хоридой)-н хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахад зөрчил үүсээгүй тул 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн томилон ажиллуулсугай.

2. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Д.Агаармандал	(Санхүү албаны дарга)
Гишүүд	М.Эрдэнэбулган	(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
	Д.Гэрэлтуяа	(Нярав)

3. Засаг даргын орлогч (Ж.Хоридой)-ийн үндсэн цалинг 1,870,000 (Нэг сая найман зуун далан мянга) тооцож, онцгой нөхцөлийн нэмэгдэл 30 (гуч) хувь, орон нутгийн нэмэгдэл 60 (жар) хувиар тус тус бодож олгохыг нягтлан бодогч (С.Нандинцэцэг)-т даалгасугай.

4. (Ж.Хоридой)-д хариуцсан ажилдаа хурдан дадлагажиж, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.МОНХХУЯГ



010000548